

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2024/58/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
2024 он	Аудитын менежер: Х.Женисбек
	Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	Ахлах аудитор: У.Ербол
	Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

БӨА-2024/58/НА-СТА-ТШЗ

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Төсвийн захирагч



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 4 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Г.АМАНТАЙ ТАНАА

2024.02.21 № 157
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй

Аудитын гол асуудал

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402237

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшний боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ж.АЙГҮЛ



Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	121,736,695.90	269,540,218.92
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	15,372,614.00	160,206,761.02
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	15,372,614.00	160,203,731.02
3121	Төгрөг	15,372,614.00	160,203,731.02
31211	Төрийн сангийн харилцах	15,372,614.00	160,203,731.02
33	АВЛАГА	1,137,616.00	3,542,644.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,137,616.00	3,542,644.00
35	БАРАА МАТЕРИАЛ	105,226,465.90	105,790,813.90
354	Хангамжийн материал	105,226,465.90	105,790,813.90
35410	Бичиг хэргийн материал	553,000.00	1,117,348.00
35420	Аж ахуйн материал	5,935,160.00	5,935,160.00
35470	Бусад хангамжийн материал	98,738,305.90	98,738,305.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,982,212,730.93	1,924,326,531.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,982,212,730.93	1,924,326,531.46
392	Биет хөрөнгө	1,775,320,730.93	1,716,082,454.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,845,948,850.18	1,845,948,850.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	(409,157,395.45)	(509,674,807.03)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	24,750,000.00	24,750,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(6,187,500.00)	(8,662,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	333,923,438.47	395,384,438.47
39206	Хуримтлагдсан элэгдэл	(219,230,309.53)	(247,675,251.09)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	131,211,748.36	152,929,748.36
39208	Хуримтлагдсан элэгдэл	(100,707,284.93)	(105,683,208.35)
39214	Бусад үндсэн хөрөнгө	61,644,200.00	61,644,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(39,520,666.39)	(45,524,666.35)
39217	Ном	152,645,650.22	152,645,650.22
393	Биет бус хөрөнгө	206,892,000.00	208,244,077.05
39301	Програм хангамж	750,000.00	2,173,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(750,000.00)	(821,161.95)
39303	Бусад биет бус хөрөнгө	206,892,000.00	206,892,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,103,949,426.83	2,193,866,750.38
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	129,748,108.13	211,888,312.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	129,748,108.13	211,888,312.00
413	Өглөг	129,748,108.13	211,888,312.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	127,900,943.60	211,888,312.00
4136	Бусад өглөг	1,847,164.53	-
41361	Байгууллагад төлөх өглөг	1,847,164.53	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,974,201,318.70	1,981,978,438.38
51	Засгийн газрын хувь оролцоо	1,974,201,318.70	1,981,978,438.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	933,880,457.00	933,880,457.00
51101	Өмч: - төрийн	933,880,457.00	933,880,457.00
512	Хуримтлагдсан үр дүн	(334,475,823.57)	(326,698,703.89)

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51210	Өмнөх үеийн үр дүн	(275,463,517.91)	(334,475,823.57)
51220	Тайлант үеийн үр дүн	(59,012,305.66)	7,777,119.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,374,796,685.27	1,374,796,685.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,103,949,426.83	2,193,866,750.38

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,646,787,502.64	3,389,992,687.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	6,129,887.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	6,129,887.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	350,648.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	350,648.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	5,779,239.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,646,787,502.64	3,383,862,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,367,774,902.64	3,102,697,500.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	32,529,302.64	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,335,245,600.00	3,102,697,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	279,012,600.00	281,165,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	279,012,600.00	281,165,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,705,799,808.30	3,382,215,567.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,705,799,808.30	3,382,215,567.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,589,875,308.30	3,265,803,158.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,887,631,022.53	2,383,532,508.76
210101	Үндсэн цалин	1,485,157,407.10	1,611,935,837.35
210102	Нэмэгдэл	366,884,515.43	664,294,362.89
210104	Урамшуулал	35,589,100.00	107,302,308.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	233,983,884.00	298,176,307.47
210201	Тэтгэврийн даатгал	158,744,884.00	198,566,012.00
210202	Тэтгэмжийн даатгал	18,809,700.00	24,194,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,047,800.00	19,355,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,761,900.00	4,838,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	37,619,600.00	51,221,795.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	308,903,457.60	363,552,668.40
210301	Гэрэл, цахилгаан	3,650,000.00	7,784,300.00
210302	Түлш, халаалт	289,698,657.60	340,547,368.40
210303	Цэвэр, бохир ус	15,554,800.00	15,221,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	766,300.00	1,600,000.00
210604	Урсгал засвар	766,300.00	1,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,272,686.00	14,044,335.22
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,272,686.00	14,044,335.22

**Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	153,317,958.17	204,897,338.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,198,340.00	36,211,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,408,500.00	26,197,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	95,711,118.17	142,488,438.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,924,500.00	116,412,409.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	115,924,500.00	116,412,409.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	115,924,500.00	116,412,409.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(59,012,305.66)	7,777,119.68
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(59,012,305.66)	7,777,119.68

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,614,258,200.00	3,384,213,448.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	350,648.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	350,648.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	350,648.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		350,648.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,614,258,200.00	3,383,862,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,335,245,600.00	3,102,697,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,335,245,600.00	3,102,697,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	279,012,600.00	281,165,300.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	279,012,600.00	281,165,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,514,749,986.00	3,160,556,300.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,514,749,986.00	3,160,556,300.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,399,052,086.00	3,044,143,891.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,884,619,400.00	2,383,532,508.76
210101	Үндсэн цалин	1,485,978,300.00	1,611,935,837.35
210102	Нэмэгдэл	363,052,000.00	664,294,362.89
210104	Урамшуулал	35,589,100.00	107,302,308.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	235,121,500.00	302,428,500.00
210201	Тэтгэврийн даатгал	159,882,500.00	205,651,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	18,809,700.00	24,194,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,047,800.00	19,355,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,761,900.00	4,838,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	37,619,600.00	48,388,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	212,034,800.00	279,565,300.00
210301	Гэрэл, цахилгаан	3,983,800.00	7,784,300.00
210302	Түлц, халаалт	192,830,000.00	256,560,000.00
210303	Цэвэр, бохир ус	15,221,000.00	15,221,000.00

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,600,000.00	1,600,000.00
210604	Урсгал засвар	1,600,000.00	1,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,187,686.00	14,044,335.22
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,187,686.00	14,044,335.22
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,488,700.00	62,973,248.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,818,800.00	36,211,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,669,900.00	26,761,848.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,697,900.00	116,412,409.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	115,697,900.00	116,412,409.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	115,697,900.00	116,412,409.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	99,508,214.00	223,657,147.02
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	78,823,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	78,823,000.00
2200	Догоод эх үүсвэрээр	-	78,823,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		78,823,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(78,823,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	99,508,214.00	144,834,147.02
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		15,372,614.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		160,206,761.02

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	933,880,457.00	1,374,796,685.27	-275,463,517.91		2,033,213,624.36
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	933,880,457.00	1,374,796,685.27	-275,463,517.91	0.00	2,033,213,624.36
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-59,012,305.66		-59,012,305.66
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	933,880,457.00	1,374,796,685.27	-334,475,823.57	0.00	1,974,201,318.70
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	933,880,457.00	1,374,796,685.27	-334,475,823.57	0.00	1,974,201,318.70
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	933,880,457.00	1,374,796,685.27	-334,475,823.57	0.00	1,974,201,318.70
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайланг үеийн үр дүн			7,777,119.68		7,777,119.68
D09	2023 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	933,880,457.00	1,374,796,685.27	-326,698,703.89	0.00	1,981,978,438.38

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		15,372,614.00		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,403,635,614.00	3,239,379,300.98	(164,256,313.02)	95.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,403,635,614.00	3,239,379,300.98	(164,256,313.02)	95.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,255,564,714.00	3,122,966,891.98	(132,597,822.02)	95.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,486,647,500.00	2,383,532,508.76	(103,114,991.24)	95.9
210101	Үндсэн цалин	1,694,146,900.00	1,611,935,837.35	(82,211,062.65)	95.1
210102	Нэмэгдэл	681,240,000.00	664,294,362.89	(16,945,637.11)	97.5
210104	Урамшуулал	111,260,600.00	107,302,308.52	(3,958,291.48)	96.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх үнэмлэхүй хөрөнгийн даатгал	310,831,100.00	302,428,500.00	(8,402,600.00)	97.3
210201	Тэтгэврийн даатгал	211,365,200.00	205,651,300.00	(5,713,900.00)	97.3
210202	Тэтгэмжийн даатгал	24,866,500.00	24,194,300.00	(672,200.00)	97.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,893,200.00	19,355,500.00	(537,700.00)	97.3
210204	Ажигүйдлийн даатгал	4,973,200.00	4,838,700.00	(134,500.00)	97.3
210205	Эрүүл мэндийн даатгал	49,733,000.00	48,388,700.00	(1,344,300.00)	97.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	279,565,300.00	279,565,300.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	7,784,300.00	7,784,300.00	-	100.0
210302	Түлш, халаалт	256,560,000.00	256,560,000.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	15,221,000.00	15,221,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,600,000.00	1,600,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	1,600,000.00	1,600,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	22,007,700.00	14,044,335.22	(7,963,364.78)	63.8
210801	Бусад нийтлэг АУТХураамж	4,400,200.00	-		
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,607,500.00	14,044,335.22	(3,563,164.78)	79.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	154,913,114.00	141,796,248.00	(13,116,866.00)	91.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	128,501,914.00	115,385,048.00	(13,116,866.00)	89.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,411,200.00	26,411,200.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	148,070,900.00	116,412,409.00	(31,658,491.00)	78.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	148,070,900.00	116,412,409.00	(31,658,491.00)	78.6
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	148,070,900.00	116,412,409.00	(31,658,491.00)	78.6
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,388,263,000.00	3,384,213,448.00	(4,049,552.00)	99.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,102,697,500.00	3,102,697,500.00	-	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжүүлсэн зардал	3,102,697,500.00	3,102,697,500.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	281,165,300.00	281,165,300.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	281,165,300.00	281,165,300.00	-	100.0
1E+05	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГА	4,400,200.00	350,648.00	(4,049,552.00)	
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлсэн зардал	4,400,200.00	350,648.00	(4,049,552.00)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	15,372,614.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,372,614.00	160,206,761.02		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	
610001	Төсвийн байгууллага	1	1	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	138	138	-	
620001	Удирдах ажилтан	1	1	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	97	97	-	
620003	Үйлчлэх ажилтан	40	40	-	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	138	138	-	
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБ)	99	99	-	
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч	1	1	-	
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч	1	1	-	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	37	37	-	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсвөөс гүйлгээ гараагүй байна.

БӨА-2024/58/НА-СТА-ТШЗ

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь “Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилан сургуулийн менежментийг сайжруулж, боловсролын үйлчилгээний хүртээмж, сургалтын чанарт ахиц гаргах” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

- Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдал явцын, өөрийн, хөндлөнгийн үнэлгээнд суурилан сурлагын хоцрогдлыг арилгах, элсэлтийн ерөнхий шалгалтаас ахиц, амжилт гаргах
- Pearson, Eduten, Medle.mn, After school зэрэг сургалтын дэмжих цахим платформд суурилсан нэмэлт хөтөлбөрийг хэрэгжүүлж, суралцагчийн ур чадвар, багшийн арга зүйд ахиц гаргах
- Ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилан үндэсний цахим системийг ашиглан багшийн хөгжлийг дэмжих, ажлын байранд хөгжих нөхцөл бололцоогоор хангах, мэргэжлийн хөгжлийн бүлгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх
- Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах тэгш боломж олгох орчныг бүрдүүлж, тэдний онцлог, сурах хэв маягт нийцсэн дэмжлэг үзүүлэх
- Сургуулийн номын сангийн үйлчилгээг сурах, сургах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хүүхдийн сурч хөгжих, төлөвших, хамтран ажиллах, мэдээлэл авахад нь туслах орчин болгон өөрчилж, үйлчилгээний нээлттэй байдлыг хангах
- Хос хэлний сургалттай сургуулийн бага ангийн монгол хэлний жишиг хөтөлбөр болон АХИС (агуулга хэлийг интеграцлан сургах) арга зүйг хэрэгжүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэв.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Сургуулийн захирлын 2021 оны А/11 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 89.9 сая төгрөгөөр буюу 4.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
----------	----------------	-----------------	----------

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	15,372.6	160,206.7	144.834.1
Авлага	1,137.6	3,542.6	2,405.0
Бараа материал	105,226.5	105,790.8	564.3
Үндсэн хөрөнгө	1,982,212.7	1,924,326.5	(57,886.2)
Нийт хөрөнгө	2,103,949.4	2,193,866.7	89,917.3
Өр төлбөр	129,748.1	211,888.3	82,140.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,974,201.3	1,981,978.4	7,777.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,103,949.4	2,193,866.7	89,917.3

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 144.8 сая төгрөгөөр нэмэгдэж 160.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь цалингийн зардал, үдийн хоолны зардал буруу төлөвлөсөнтэй холбоотой байна.

Дансны авлага 2.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь хувь хүний орлогын албан татварын авлага байна.

Бараа материалын данс 0.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн данс 57.8 сая төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл оны эцэст 82.1 сая төгрөгөөр нэмэгдэж 211.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь халаалтын зардлын өглөг байна. Энэ нь орон нутгаас халаалтын зардлын төсвийг дутуу төлөвлөж, хуваарилж байгаатай холбоотой байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 7.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,487,9 сая төгрөг, нийт зарлагыг 2,487.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 274.6 сая төгрөгөөр бууруулж, 2,213.3 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн тодотгол хийгдэж нийт дүнгээр 889.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 3,102.7 сая төгрөгөөр баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,102.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 281.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,102.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 281.2 сая төгрөгийн санхүүжилт олгож, жилийн эцэст 160.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт үндэслэлгүй хийгдсэнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,239.4 сая төгрөг буюу 95.7 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71802	Ерөнхий боловсрол	3,403,634.7	3,239,379.3	164,256.4	95.7%
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	7,043.0	7,043.0	0	100%
80312	Сургалт семинар	5,072.8	4,430.0	642.8	48.2%
81605	Эрүүл мэндийг дэмжих	7,043.0	3,396.5	3,646.5	48.3%
81801	Үдийн цай хөтөлбөр	148,070.9	116,412.4	31,658.5	78.6%
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	79,049.2	79,049.2	0	100%
81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	19,558.3	10,380.0	9,178.3	53%
81827	Бичиг үсгийн боловсрол	9,660,100	9,660,100	0	100%
81834	Боловсролын стандарт сургалт	2,519,733.9	2,414,034.1	105,699.8	95.8%
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	322,839.0	313,458.0	9,380.9	97%
81848	Сурах бичиг түрээс	4,400.2	350.6	4,049.5	8%
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	281,165.3	281,165.3	0	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвөөр гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 98.6 сая төгрөгийн бараа материал, 78.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 297 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 2,705.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 40.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус газар нь батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаагаа явуулж, жилийн эцэст өр, авлагагүй ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан ба алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 3,344,444.0 мянган төгрөгийн 56 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 442,686.1 мянган төгрөгийн 22 гүйлгээг байршуулахаас цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 3,344,444.0 мянган төгрөгийн 56 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 286,027.3 мянган төгрөгийн 13 мөнгөн гүйлгээ,

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, санхүүгийн хагас жилийн тайлан, байгууллагын батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, бусад мэдээллүүдийг мэдээлээгүй буюу шилэн дансны мэдээллийн хэрэгжилт 34.5 хувьтай, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгөхөөр шийдэрлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудитын хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 4 албан шаардлага, 1 төлбөрийн актын хэрэгжилтийг давтан шалгаж үзэхэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	1,582,759.5	3	906,965.2	57.3%
Зөвлөмж	1	1,523.5	1	1,523.5	100%
Нийт дүн	5	1,584,283.0	1	908,488.7	54.7%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудитаар эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн тул төсвийн зарцуулалтыг гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,600.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,600.0 мянган төгрөгийн алдааг залруулсан.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,
БӨА-2024/58/НА-СТА-ТШЗ

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн үр дүнгийн тайланд урсгал засварын зардлыг 1,600.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулсан.

Аудитаар нийт 3,633,771.3 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 3,630,471.3 мянган төгрөгийн зөрчилд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгч, 3,300.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Байхгүй

5.2 Албан шаардлага

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 3,344,444.0 мянган төгрөгийн 56 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 442,686.1 мянган төгрөгийн 22 гүйлгээг байршуулахаас цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 3,344,444.0 мянган төгрөгийн 56 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 286,027.3 мянган төгрөгийн 13 мөнгөн гүйлгээ, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, санхүүгийн хагас жилийн тайлан, байгууллагын батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, бусад мэдээллүүдийг мэдээлээгүй буюу шилэн дансны мэдээллийн хэрэгжилт 34.5 хувьтай, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.4-т “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх”, 5 дугаар зүйлийн 5.1.4-т “мэдээллийг тогтмол шинэчилж байх”, 6 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6 дугаар зүйлийн 6.4.5- т” цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 7 дугаар зүйлийн 7.1-д “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ”, Засгийн газрын 2019 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.
БӨА-2024/58/НА-СТА-ТШЗ

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант онд 3,300.0 мянган төгрөгийн түрээсийн сурах бичгийг сурагчдад тараасан боловч авлагаар бүртгээгүй, тооцооны данс дамжуулахгүйгээр төлбөрийг бэлнээр авч, бүрдэл дутуу баримтаар зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 -д “Үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-т “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно...”, 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтууд, иж бүрэн байх, ангилал, оршин байх гэсэн батламж мэдэгдэлд нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Түрээсийн сурах бичгийг авлагаар бүртгэж тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн үр дүнгийн тайланд урсгал засварын зардлыг дутуу тайлагнасан	1	1,600.0			1	1,600.0	1	1,600.0				
Дүн	1	1,600.0			1	1,600.0	1	1,600.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

БӨА-2024/58/НА-СТА-ТШЗ

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Түрээсийн сурах бичгийг авлагаар бүртгээгүй	1	3,300.0					1	3,300.0				
Дүн	1	3,300.0					1	3,300.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг оруулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй	1	3,630,471.3			1	3,630,471.3		
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	3,630,471.3			1	3,630,471.3		